



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН  
ГАЗАРТ

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

46083 Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,  
Нутгийн удирдлагын ордон, 204 тоот  
Утас: (976)70532849, Факс: (976)70532111,  
И-мэйл: info@omnogovi.gov.mn, Вэб сайт: www.omnogovi.gov.mn

2019.05.21 № 2-1305  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Тендер дахин зарлуулах тухай**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 7/5 дугаар тогтоолын тавдугаар хавсралтын 47 дахь заалт “Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх ажил”-ыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Шүүхийн шинжилгээний албанд тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр төлөвлөсөн.

Тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар зарласан тендерт оролцсон компани нь шаардлага хангаагүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шууд гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид ирүүлсэн.

Шүүхийн шинжилгээний албаны боловсруулсан техникийн тодорхойлолтоор шууд гэрээ байгуулах компани олдохгүй байх тул захиалагч тендерийн техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулсан.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг дахин зохион байгуулж өгнө үү.

ДАРГА



Ө.БАЯНМӨНХ

БАТЛАВ  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Ө.БАЯНМӨНХ

2019 оны 05 сарын 22

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНД  
НИЙЛҮҮЛЭХ ЛАБОРАТОРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН  
ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2019.05.20

Даланзадгад

№	Тоног төхөөрөмжийн нэр	Техникийн үзүүлэлт	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг
1	Микроскоп	SM-3TZ-54S-9M дүйцэхүйц Хэт улаан, ягаан гэрэлтэй нм нь 365-4-11	SM-3TZ-54S-9M дүйцэхүйц	1 ширхэг
2	8M Digital camera	MD1800 дүйцэхүйц	MD1800 дүйцэхүйц	1 ширхэг
3	Мөр судлалын лабораторийн ширээ, сандал	Хүндрүүлэгчтэй, өндөр шахалттай хавтангаар хийгдсэн, цахилгаанжилтаас хамгаалагдсан полиэтилен будгаар өнгөлж будсан. Ширээний дээд талын тавцанг хүчил шүлт, органик уусгагч, химийн бодист тэсвэртэй, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан бүтээгдэхүүн байна. Сандал нь: Тавцан өндөр, нам болдог дээш, доош болдог дугуйтай		Ширээ -1 Сандал -1
4	Микроскопын давхар уян гэрэл	Хэт улаан, ягаан гэрэлтэй нм нь 365-4-11 дүйцэхүйц	HL250-AY дүйцэхүйц	1 ширхэг

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ  
ГАРГАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Ц.ЦЭВЭЭН